

# ХААН СОЁМБО АУДИТ ХХК



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Радио телевизийн сүлжээний газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/33/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2023 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Давааням  
Утас: 92113932 Цахим хаяг: [davaanyamb@audit.gov.mn](mailto:davaanyamb@audit.gov.mn)

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа  
Утас: 99065668 Цахим хаяг: [info@khaansoyomboaudit.mn](mailto:info@khaansoyomboaudit.mn)

Гүйцэтгэсэн аудитор: Н.Бадамханд  
Утас: 99042699 Цахим хаяг: [khaan.soyombo.audit@gmail.com](mailto:khaan.soyombo.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

<b>1.АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ.....</b>	<b>3</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....</b>	<b>5</b>
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
<b>3. АУДИТЫН ТАЙЛАН.....</b>	<b>10</b>
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	10
3.2 Байгууллагын гадаад дотоод орчин .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	11
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	11
3.5.2 Төсвийн гүйцэтгэл .....	11
3.5.3 Нэмэлт төсөв .....	11
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН .....</b>	<b>12</b>
4.1 Ерөнхий зүйл .....	12
4.2 Материаллаг байдал .....	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	12
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
4.5.1 Завсрын аудитын талаар .....	13
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	13
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....</b>	<b>13</b>
5.1 Төлбөрийн акт .....	13
5.2 Албан шаардлага .....	13
5.3 Зөвлөмж.....	13
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....</b>	<b>14</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ДББ.02.04 № 01/143  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН РАДИО  
ТЕЛЕВИЗИЙН СҮЛЖЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГА Г.ПУНЦАГБАЛЖИР ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Радио телевизийн сүлжээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Радио телевизийн сүлжээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд 54,926.2 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч үндсэн хөрөнгө дансыг нэмэгдүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Туслах үйл ажиллагааны төлөвлөгөөг 14,000.0 мянган төгрөгөөр тасалсан, өмнөх онд үүссэн 2,131,7 мянган төгрөгийг барагдуулаагүй ба тайланд онд авлагыг 500.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2022 онд 1 зорилтын хүрээнд 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласнаас 86 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>309,786,263.23</u></b>	<b><u>304,077,671.48</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	5,768,336.93	132,545.68
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	511,302.00	11,302.00
31110	Төгрөг	511,302.00	11,302.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	5,257,034.93	121,243.68
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	5,257,034.93	121,243.68
31211	Төрийн сангийн харилцах	5,257,034.93	121,243.68
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	2,131,748.00	2,631,748.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	500,000.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	2,131,748.00	2,131,748.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	301,886,178.30	301,313,377.80
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	301,886,178.30	301,313,377.80
35410	Бичиг хэргийн материал	486,000.00	710,700.00
35420	Аж ахуйн материал	3,939,162.00	1,312,249.00
35430	Сэлбэг хэрэгсэл	278,803,762.90	280,493,662.90
35440	Түлш, шатах тослох материал	2,957,788.00	2,833,000.50
35470	Бусад хангамжийн материал	15,699,465.40	15,963,765.40
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>3,604,186,097.74</u></b>	<b><u>3,276,405,237.42</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,604,186,097.74	3,276,405,237.42
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	824,697,097.74	496,916,237.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	244,466,790.00	244,466,790.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-24,748,159.32	-31,622,648.32
39203	Авто-тээврийн хэрэгсэл	45,186,934.20	43,061,934.20
39204	Хуримтлагдсан элэгдэл	-24,794,074.57	-26,734,107.76
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,713,782,715.94	3,756,583,915.94
39206	Хуримтлагдсан элэгдэл	-3,134,443,928.10	-3,491,828,108.52
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,517,497.91	19,517,497.91
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,270,678.32	-16,529,036.03
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	2,779,489,000.00	2,779,489,000.00
39301	Програм хангамж	2,270,000.00	2,270,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,270,000.00	-2,270,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	2,779,489,000.00	2,779,489,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>3,913,972,360.97</u></b>	<b><u>3,580,482,908.90</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>3,913,972,360.97</u></b>	<b><u>3,580,482,908.90</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,913,972,360.97	3,580,482,908.90
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,061,676,958.00	4,061,676,958.00
51101	Өмч: - төрийн	4,061,676,958.00	4,061,676,958.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-503,390,351.23	-836,879,803.30
51210	Өмнөх үеийн үр дүн	-503,390,351.23	-503,390,351.23
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-333,489,452.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	355,685,754.20	355,685,754.20
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>3,913,972,360.97</u></b>	<b><u>3,580,482,908.90</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>182,044,420.02</b>	<b>355,880,462.92</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>45,600,600.02</b>	<b>39,031,942.92</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	45,600,600.02	39,031,942.92
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	45,600,600.02	39,031,942.92
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	660,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	44,940,600.02	39,031,942.92
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>136,443,820.00</b>	<b>316,848,520.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	136,443,820.00	316,848,520.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	136,443,820.00	316,848,520.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>291,293,586.78</b>	<b>689,166,414.99</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>291,293,586.78</b>	<b>689,166,414.99</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	290,293,586.78	676,070,774.99
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	94,659,466.00	200,331,858.83
210101	Үндсэн цалин	87,323,466.00	187,770,858.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,336,000.00	12,561,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	13,159,481.72	21,419,511.47
210201	Тэтгэврийн даатгал	9,390,800.36	14,565,267.82
210202	Тэтгэмжийн даатгал	980,195.90	1,713,560.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	767,355.85	1,370,848.74
210204	Ажилгүйдлийн даатгал	183,739.96	342,712.16
210205	Эрүүл мэндийн даатгал	1,837,389.65	3,427,121.84
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	12,111,743.94	26,741,429.45
210301	Гэрэл, цэвэрлэг	11,052,196.44	20,644,641.95
210302	Түлш, халаалт	647,047.50	4,797,787.50
210303	Цэвэр, бохир ус	412,500.00	550,000.00
210304	Байрны түрээс	00.00	749,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,271,176.00	5,426,275.00
210401	Бичиг хэрэг	182,700.00	265,100.00
210402	Тээвэр, шатахуун	2,080,000.00	3,450,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	371,314.00	796,570.00
210404	Ном, хэвлэл	75,000.00	114,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	562,162.00	799,805.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,781,390.00	23,335,680.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	536,920.00	3,549,630.00
210604	Урсгал засвар	5,244,470.00	19,786,050.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,281,912.00	3,713,946.00
210702	Дотоод албан томилолт	1,281,912.00	3,713,946.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	11,195,228.00	28,553,271.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,016,012.00	10,395,275.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,947,000.00	15,553,000.00
210807	Газрын төлбөр	2,232,216.00	2,604,996.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	148,833,189.12	366,548,803.24
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	520,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	148,313,189.12	366,548,803.24
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,000,000.00	13,095,640.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,000,000.00	13,095,640.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	13,095,640.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-109,249,166.76</b>	<b>-333,285,952.07</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	203,500.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	203,500.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	00.00	-203,500.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-109,249,166.76</b>	<b>-333,489,452.07</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,061,676,958.00	355,685,754.20	-503,390,351.23	3,913,972,360.97
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,061,676,958.00	355,685,754.20	-503,390,351.23	3,913,972,360.97
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,061,676,958.00	355,685,754.20	-503,390,351.23	3,913,972,360.97
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-333,489,452.07	-333,489,452.07
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,061,676,958.00	355,685,754.20	-836,879,803.30	3,580,482,908.90

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/Төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>315,906,730.00</b>	<b>316,848,520.00</b>	
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,820,000.00</b>	<b>00.00</b>	
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,820,000.00	00.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,820,000.00	00.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	00.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,320,000.00	00.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>314,086,730.00</b>	<b>316,848,520.00</b>	
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	314,086,730.00	316,848,520.00	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	314,086,730.00	316,848,520.00	
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>317,713,738.21</b>	<b>322,484,311.25</b>	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>317,713,738.21</b>	<b>322,484,311.25</b>	
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>313,993,738.21</b>	<b>309,388,671.25</b>	
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	194,291,512.91	200,831,858.83	
210101	Үндсэн цалин	182,213,012.91	188,270,858.83	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,078,500.00	12,561,000.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>21,149,227.01</b>	<b>21,419,511.47</b>	
210201	Тэтгэврийн даатгал	14,862,996.30	14,565,267.82	
210202	Тэтгэмжийн даатгал	1,623,984.02	1,713,560.91	
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,272,303.50	1,370,848.74	
210204	Ажилгүйдлийн даатгал	308,177.41	342,712.16	
210205	Эрүүл мэндийн даатгал	3,081,765.78	3,427,121.84	
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>26,211,218.29</b>	<b>26,596,641.95</b>	
210301	Гэрэл, цахилгаан	21,378,030.29	20,644,641.95	
210302	Түлш, халаалт	3,652,688.00	4,653,000.00	
210303	Цэвэр, бохир ус	412,500.00	550,000.00	
210304	Байрны түрээс	768,000.00	749,000.00	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>12,001,190.00</b>	<b>5,770,062.00</b>	
210401	Бичиг хэрэг	493,850.00	489,800.00	
210402	Тээвэр, шатахуун	9,784,612.00	3,470,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	754,256.00	796,570.00	

Радио телевизийн сүлжээний газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210404	Ном, хэвлэл	105,400.00	114,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	863,072.00	898,892.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>31,829,850.00</b>	<b>22,503,380.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,299,450.00	1,291,430.00
210604	Урсгал засвар	26,530,400.00	21,211,950.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,251,133.00</b>	<b>3,713,946.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,251,133.00	3,713,946.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>22,739,607.00</b>	<b>28,553,271.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,780,347.00	10,395,275.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,774,000.00	15,553,000.00
210807	Газрын төлбөр	5,185,260.00	2,604,996.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>520,000.00</b>	<b>00.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	520,000.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,720,000.00</b>	<b>13,095,640.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,720,000.00</b>	<b>13,095,640.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,720,000.00	13,095,640.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>-1,807,008.21</u></b>	<b><u>-5,635,791.25</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>8,539,900.00</b>	<b>00.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>8,539,900.00</b>	<b>00.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>8,539,900.00</b>	<b>00.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,539,900.00	00.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-8,539,900.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-10,346,908.21</b>	<b>-5,635,791.25</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>17,620,745.14</b>	<b>5,768,336.93</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>5,768,336.93</b>	<b>132,545.68</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	341,145,320.00	322,484,311.25	-18,661,008.75	94.53
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	341,145,320.00	322,484,311.25	-18,661,008.75	94.53
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	328,145,320.00	309,388,671.25	-18,756,648.75	94.28
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	206,019,480.00	200,831,858.83	-5,187,621.17	97.48
210101	Үндсэн цалин	190,890,892.00	188,270,858.83	-2,620,033.17	98.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,128,588.00	12,561,000.00	-2,567,588.00	83.03
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	26,789,440.00	21,419,511.47	-5,369,928.53	79.96
210201	Тэтгэврийн даатгал	18,216,819.20	14,565,267.82	-3,651,551.38	79.96
210202	Тэтгэмжийн даатгал	2,143,155.20	1,713,560.91	-429,594.29	79.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,714,524.16	1,370,848.74	-343,675.42	79.96
210204	Ажилгүйдлийн даатгал	428,631.04	342,712.16	-85,918.88	79.96
210205	Эрүүл мэндийн даатгал	4,286,310.40	3,427,121.84	-859,188.56	79.96

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	27,648,000.00	26,596,641.95	-1,051,358.05	96.20
210301	Гэрэл, цахилгаан	21,000,000.00	20,644,641.95	-355,358.05	98.31
210302	Түлш, халаалт	4,680,000.00	4,653,000.00	-27,000.00	99.42
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	550,000.00	-650,000.00	45.83
210304	Байрны түрээс	768,000.00	749,000.00	-19,000.00	97.53
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,545,000.00	5,770,062.00	-774,938.00	88.16
210401	Бичиг хэрэг	650,000.00	489,800.00	-160,200.00	75.35
210402	Тээвэр, шатахуун	3,695,000.00	3,470,000.00	-225,000.00	93.91
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	850,000.00	796,570.00	-53,430.00	93.71
210404	Ном, хэвлэл	150,000.00	114,800.00	-35,200.00	76.53
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,200,000.00	898,892.00	-301,108.00	74.91
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	24,280,000.00	22,503,380.00	-1,776,620.00	92.68
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,300,000.00	1,291,430.00	-8,570.00	99.34
210604	Урсгал засвар	22,980,000.00	21,211,950.00	-1,768,050.00	92.31
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,500,000.00	3,713,946.00	-786,054.00	82.53
210702	Дотоод албан томилолт	4,500,000.00	3,713,946.00	-786,054.00	82.53
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	32,363,400.00	28,553,271.00	-3,810,129.00	88.23
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,905,000.00	10,395,275.00	-509,725.00	95.33
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,894,000.00	15,553,000.00	-341,000.00	97.85
210807	Газрын төлбөр	5,564,400.00	2,604,996.00	-2,959,404.00	46.82
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	13000000.00	13095640.00	95,640.00	100.74
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	13,000,000.00	13,095,640.00	95,640.00	100.74
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,000,000.00	13,095,640.00	95,640.00	100.74
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	341,145,320.00	316,848,520.00	-24,296,800.00	92.88
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	327,144,920.00	316,848,520.00	-10,296,400.00	96.85
131001	Улсын төсвөөс санхүүжих	327,144,920.00	316,848,520.00	-10,296,400.00	96.85
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	14,000,400.00	00.00	-14,000,400.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,000,400.00	00.00	-14,000,400.00	0.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	5,768,336.93	5,768,336.93	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	132,545.68	132,545.68	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	22.00	21.00	-1.00	95.45
620001	Удирдах ажилтан	02.00	02.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	13.00	-1.00	92.86
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00	0.00	100.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл аймгийн Радио, телевиз сүлжээний газар нь Харилцаа холбоо, Мэдээллийн технологийн шинэ дэвшилтэт технологийг ашиглан хэрэглэгчийн өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээг нь хангасан нийлмэл, орон зайнаас үл хамаарсан Радио телевизийн өргөн нэвтрүүлгийн үндэсний тоон технологийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх зорилготой байгууллага юм.

#### 3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Хөвсгөл аймгийн Радио, телевизийн сүлжээний газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Радио өргөн нэвтрүүлэг, телевизийн нэвтрүүлэг дахин дамжуулах, хэт богино долгионоор нэвтрүүлэг, FM дамжуулах, радио холбооны тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, сансрын сүлжээ байгуулах, интернэт радио, интернэт телефоны үйлчилгээгээр хангах.

Байгууллагын үндсэн мэдээлэл, түүний гадаад орчин болон дотоод үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн үйл явцыг судалж, ойлгосноор эрсдэлтэй асуудлыг тодорхойлж баримтжуулав.

Байгууллагад мөрдөгдөх дараах хууль тогтоомжуудад тайлант онд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Радио телевизийн сүлжээний газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Радио телевизийн сүлжээний газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 333.5 сая төгрөгөөр буюу 8.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Дансны авлага	2.1	2.6	0.5
Бараа материал	301.9	301.3	(0.6)
Үндсэн хөрөнгө	3,604.2	3,276.4	(327.8)
Биет бус хөрөнгө	2,779.5	2,779.5	-
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,914.0</b>	<b>3,580.5</b>	<b>(333.5)</b>
Дансны өглөг	-	-	-
-төрийн	4,061.7	4,061.7	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	355.7	355.7	-
Хуримтлагдсан үр дүн	(503.4)	(503.4)	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,913.9</b>	<b>3,580.4</b>	<b>(333.5)</b>

Үндсэн хөрөнгө данс 327.7 сая төгрөгөөр хасагдсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг үндсэн үйл ажиллагаанаас 11.0 сая, улсын төсвөөс 312.8 сая, нийт зарлагыг 388.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 47.3 сая төгрөгөөр бууруулж, 341.1 сая төгрөгөөр баталсан байна.

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант оны батлагдсан төсвийг 14.3 сая төгрөгөөр өсгөж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 327.1 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 14.0 сая төгрөг бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 316.8 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авсан ба 10.3 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх онд 5.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 0.1 сая төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 322.4 сая төгрөг буюу 94.5 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний зардал

/сая төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>70417</b>	<b>Радио телевизийн сүлжээний газар</b>	<b>341.1</b>	<b>322.4</b>	<b>(18.7)</b>	<b>94.5</b>
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	328.1	309.3	(18.7)	94.3
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	13.0	13.09	0.09	100.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Радио телевизийн сүлжээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан Соёмбо Аудит ХХК-ийн чанарын хяналт, ахлах аудитор Н.Бадамханд гүйцэтгэж, хяналтыг анхан шатанд Хаан Соёмбо Аудит ХХК-ийн захирал Х.Диймаа, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Радио телевизийн сүлжээний газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар буюу 12.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 8.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилот, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

**Илрүүлэлт:**

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2022 оны цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын 47.0 сая төгрөгийн мэдээллийг хугацаа хоцорч оруулсан, орлогын 33.9 сая төгрөгийн мэдээллийг огт оруулаагүй бусад мэдээллийг байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.5 дахь заалттай нийцэхгүй байгаа ба нийцсэн бөгөөд зохистой гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөвлөмж хүргүүлсэн.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Хөвсгөл аймгийн Радио телевизийн сүлжээний газарт завсрын аудит хийгээгүй.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар 8.3 сая төгрөгийн алдааг илрүүлж, залруулсан байна.

**4.6 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ**

Дараагийн аудитаар онцгойлон үзэх асуудал байхгүй байна.

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 97,5 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> -ийг дахин давтахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой залруулга хийгдээгүй болно.

**5.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

**5.2 Албан шаардлага**

Албан шаардлага өгөөгүй болно.

**5.3 Зөвлөмж**

**1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:**

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2022 оны цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын 47.0 сая төгрөгийн мэдээллийг хугацаа хоцорч оруулсан, орлогын 33.9 сая төгрөгийн мэдээллийг огт оруулаагүй бусад мэдээллийг байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.5 дахь заалттай нийцэхгүй байгаа ба нийцсэн бөгөөд зохистой гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, хугацаанд нь ил тод мэдээлж байх

**2. Туслах үйл ажиллагааны орлоготой холбоотой асуудал**

**Илрүүлэлт:**

Туслах үйл ажиллагааны төлөвлөгөөг 14.0 сая төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх заалтыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Зөвлөмж:**

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Туслах үйл ажиллагааны орлогыг бүрэн бүрдүүлэхэд анхаарч ажиллах

### 3. Авлага данстай холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Өмнөх онд үүссэн 2.1 сая төгрөгийг барагдуулаагүй ба тайланд онд авлагыг 0.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Зөвлөмж:

Өмнөх оны авлагыг бүрэн барагдуулж, дахин нэмэгдүүлэхгүй ажиллах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орлого бүрдүүлээгүй	1	14.0					1	14.0				
Авлага барагдуулаагүй	1	2.6					1	2.6				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>16.6</b>					<b>2</b>	<b>16.6</b>	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээлээгүй	2	80.9	-	-	-	-	1	80.9
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>80.9</b>	-	-	-	-	<b>1</b>	<b>80.9</b>

### АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

ЧАНАРЫН ХЯНАЛТ, АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЫМ ОГНОО:

Х.ДИЙМАА

Н.БАДАМХАНД

